



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/344

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төрийн байгууллагын төрийн үйлчилгээг соёлтой чанартай, хүнд сурталгүй, түргэн шуурхай хүргэх зорилгоор 9 байгууллагад Олон улсын ISO 9001:2015 менежментийн тогтолцоог нэвтрүүлэх үйл ажиллагааны урьдчилгаа санхүүжилтэд 10,0 сая төгрөг /Арван сая/-ийг зарцуулсугай.

2. Арга хэмжээний урьдчилгаанд зарцуулах 10,0 сая төгрөгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, арга хэмжээний жагсаалт”-ын 5-ын 5.7-д заасан арга хэмжээний хэмнэлтээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/- нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б. ДҮГЭРЖАВ

